

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.11.18

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын 10-р сарын инфляц 2.6% болж өмнөх сараас өндөр гарлаа.
- ХНС-ийн хүүг бууруулах магадлал буурлааа.
- АНУ-ын ЗГ-ын үр ашигт байдлыг зохицуулах яамны дарга Илон Маск болно.
- БНХАУ-ын эдийн засагт дефляц үргэлжилсээр байна.
- Дефляц нь компанийн ашиг орлогыг багасгахаас гадна эдийн засгийн өсөлтийн дохиог сулруулж, хөрөнгө оруулах идэвхийг бууруулдаг.

2024 он 11-р сарын 18

Dow Jones	43,444.99
S&P 500	5,870.62
Nasdaq	18,680.12
DAX	19,210.81
FTSE 100	8,063.61
S&P/ASX 200	8,312.40
HANG SENG	19,666.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-0.70%	-1.91%	0.39%	15.27%	24.32%	22.03%
S&P 500	-1.32%	-2.18%	0.10%	23.08%	30.05%	24.96%
Nasdaq	-2.24%	-3.21%	1.03%	24.44%	32.24%	16.33%

2024 оны 11 сарын 18-ны 12:40

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.27%	-1.22%	-2.27%	14.68%	20.68%	18.88%
FTSE 100	-0.09%	-0.76%	-3.53%	4.27%	7.45%	11.63%

2024 оны 11 сарын 18-ны 12:40

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.18%	0.43%	0.23%	9.37%	17.77%	12.24%
Hang Seng	1.18%	-3.78%	-5.52%	15.30%	12.61%	-21.54%

2024 оны 11 сарын 18-ны 12:40

ЗӨВЛӨМЖ

АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн эдийн засагт үзүүлэх нөлөө:

Импортын барааны өндөр тариф болон тэг хувийн татвараас шалтгаалан инфляц өсөх магадлалтай байна. БНХАУ-ын Ардын Их хурлын гаргасан бодлого шийдвэрээс шалтгаалан Хятадын хөрөнгийн зах зээлийн хувь заяа шийдэгдэнэ.



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Зах зээлийн хүчтэй өсөлт саарч уналаа

Өнгөрсөн долоо хоногт S&P 500 индекс 2.18%, NASDAQ индекс 3.21%-иар унаж ерөнхийлөгчийн сонгуулийн нөлөөгөөр дээд цэгтээ хүрээд байсан АНУ-ын хөрөнгийн зах зээлд уналт орж ирлээ. Мэдээж инфляцын тоо мэдээлэл хүлээлтийн дагуу гарсан ч өнгөрсөн сараас өссөн үзүүлэлттэй байж мөн сонгуулийн үеэр худалдан авалт хийсэн хөрөнгө оруулагч нар ашгаа хэрэгжүүлэн гарсан нь уналтад голлон нөлөөлөөд байна.

Эдийн засгийн үзүүлэлтүүд болон ХНС-ийн мэдэгдэл

Лхагва гарагт инфляцын мэдээллээр суурь инфляц (хоол хүнс, эрчим хүчнээс бусад) 0.3%-иар өссөн нь хүлээлтийн дагуу гарчээ. Гэсэн хэдий ч орон сууцны үнэ өндөр хэвээр байгаа нь жилийн инфляцыг 2.4%-иас 2.6%-д хүргэж нэмэгдүүлсэн байна.

ХНС-ийн дарга Жером Пауэлл пүрэв гарагт эдийн засагт хүү бууруулах шаардлагагүй гэсэн мэдэгдэл хийж, зах зээлийн хүлээлтэд сөргөөр нөлөөлөв. Ирэх 12-р сард хүүг 0.25%-иар бууруулах магадлал 64.6%-иас 58.4%-д, 2025 он гэхэд нийт 1%-иар бууруулах магадлал 41.3%-иас 32.6%-д хүрч буурсан байна.

Цахилгаан автомашины зах зээл ба Илон Маск

Цахилгаан автомашины салбарын хувьцаанууд долоо хоногийн эхэнд өссөн ч сүүлээр буурав. Tesla компанийн хувьцаа Даваа гарагт оргилдоо хүрч, сонгуулийн өмнөх үеэс хойш 42.63%-иар өссөн байна. Энэ нь Илон Маскыг шинэ засгийн газарт чухал үүрэг гүйцэтгэнэ гэх хүлээлттэй холбоотой. Тухайлбал, Маск шинэ “Засгийн газрын үр ашигт байдлын яам”-ны даргаар томилогдох мэдээлэл гарсан.

Үүний зэрэгцээ, Биткойны үнэ Лхагва гарагт оргилдоо хүрч, сонгуулийн өмнөх үетэй харьцуулахад 32.46%-иар өссөн нь криптовалютын зохицуулалт уян хатан болох магадлалтай холбоотой байв.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хөрөнгийн зах зээлд дефляци үргэлжилсээр байгаа, АНУ-ын шинээр сонгогдсон ерөнхийлөгч Дональд Трампын засаг захиргааны зүгээс татвар нэмэх магадлалтай гэсэн болгоомжлол нь хөрөнгө оруулагчдын итгэлийг буурууллаа. Шанхайн Composite индекс 3.52%-иар унасан бол CSI 300 индекс 3.29%-иар уналаа. Харин Хонгконгийн Hang Seng индекс 6.28%-иар огцом унасан нь цаашид ч уналт үргэлжлэх хүлээлтийг үүсгэлээ.

Инфляцын үзүүлэлт 0.3% буюу хүлээлтээс бага гарлаа

Хэрэглээний үнийн индекс (CPI) аравдугаар сард жилийн дүнгээр 0.3%-иар өссөн нь шинжээчдийн таамаглаж байснаас бага байв. Энэ нь есдүгээр сарын 0.4%-ийн өсөлтөөс буурсан үзүүлэлт бөгөөд үүнд хүнс, эрчим хүчний үнэ буурсан нь голлон нөлөөлжээ. Харин нөгөө талд үйлдвэрлэлийн үнэ 2022 оны сүүл үеэс хойш тасралтгүй дефляцтай хэвээр байгаа ажээ. Дефляц нь компанийн ашиг орлогыг багасгахаас гадна эдийн засгийн өсөлтийн дохиог сулруулж, хөрөнгө оруулах идэвхийг бууруулдаг.

Жижиглэнгийн худалдаа бага зэрэг өсөж, ажилгүйдлийн түвшин бага зэрэг буурав

Жижиглэн худалдааны борлуулалт аравдугаар сард жилийн дүнгээр 4.8%-иар өсөж, есдүгээр сарын 3.2%-иас ахисан ба энэ нь хоёрдугаар сараас хойших хамгийн өндөр өсөлт байлаа. Үйлдвэрийн гарц жилийн дүнгээр 5.3%-иар өссөн нь есдүгээр сарын 5.4%-ийн өсөлтөөс бага байж, шинжээчдийн таамаглалд хүрсэнгүй. Үүнд автомашины борлуулалт сул байдал нөлөөлсөн байна. Харин хотын ажилгүйдлийн түвшин 9-р сарын 5.1%-аас аравдугаар сард 5%-д хүрч бага зэрэг буурсан байна.

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хямралын дохио зөөлрөв

70 хотын шинэ орон сууцны үнэ аравдугаар сард өмнөх сараас 0.5%-иар буурсан нь 3-р сараас хойших хамгийн багаар унасан тохиолдол байлаа. Энэ нь Хятадын Засгийн газрын орон сууцны зах зээлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдтэй холбоотой. Үүнд:

- Орон сууцны зээлийн хүүг бууруулах,
- Томоохон хотуудад ордон худалдан авах хязгаарлалтыг зөөлрүүлэх,
- Орон сууцны татварыг багасгах зэрэг бодлого оржээ.

Эдгээр арга хэмжээнүүдийн үр дүнд орон сууцны үнийн уналт удааширсан гэж үзэж байна.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал

aktiguu published on TradingView.com, Nov 18, 2024 12:37 UTC+8

Hang Seng Index, 10, HKD C19,395.50 H19,781.08 L19,470.43 C19,655.58 +229.24 (+1.18%)



ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning November 11, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
monday.com	ZETA	shopify	SoundHound	HUT8	NU	DIS	AMAT	BABA	
ICL	GRAB	PLUG	MARA	CYBERARK	CSCO	INTUITIVE	ASTS	AIM	
GLOBAL SHIPLEASE	LUMINAR	CAVA	MARATHON	HIVE	d-local	JD.COM	OKLO	Spectrum	
aramark	ASSERTIO	SEA	SPOT	SSYS	BEAZER	NICE	DESP	wisa	
LINC	AGO	NOVAVAX	GOXY	TOWER	KULR	bilibili	GLOB	Bio-Path Holdings	
LIQUIDIA	ANGI	NOVAVAX	GOXY	PULCRUM	OptimizeRx	Advanced	POST	nexxon	
nuwellis	DOUBLE	Hertz	BSEM	ARCOS	SMITH	SHOW	ORIGIN		
RadNet	VALEO	TALEN	ROCKET	BITCOIN	CAPRICOR	Brookfield	Panbela		
ROCKWELL	STEREOTAXIS	Bitfarms	TERAWULF	Paysafe	bionano	NotEase	sabesp		
SAPIENS	TALOS	CRONOS	instacart	INNOVIZ		Ocular	emeren		

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning November 18, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
BIT DIGITAL	SYMB	WALMART	POWELL	NIO	NVIDIA	Baidu	elastic	Global Blue	
BITDEER	Trip.com	WORKHORSE	THE AZEK COMPANY	TARGET	snowflake	Pinduoduo	ROSS	addex	
TWIST	bellring	LOWE'S	KEYSIGHT TECHNOLOGIES	ZIM	paloalto	JOHN DEERE	Gap Inc.		
CHANG	tuya	X P E N G	ZTO	TJX	jack	B's	intuit		
BRADY	AECOM	Medtronic	DOLBY	WIX	Copa Airlines	vestis	Matthews		
MONDEE	zenvia	FUTU	danimer scientific	ODYCOM	SQM	WARNER MUSIC GROUP	NetApp		
SELECTAR	VERTICALS	唯品会	STAR BULK	WILLIAMS-SONOMA	MAXIMUS	贝壳	Capart		
LAZYDAYS		新加坡	KORE	Berry	BBVA	爱奇艺	UGI		
		VIKING	LABOY	万物新生	duostech	NANOX	NATURAL		
		ATOUR GROUP	360	Canaan	CARLYLE	SHOE	LGTY		